



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/134

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, "Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор баталсан "Элэг бүтэн Монгол" хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Эрүүл мэнд хөдөлгөөн хөгжил" дэд хөтөлбөр батлах тухай 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд зорилтод насны даатгуулагчийг элэгний өвчлөлийн эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулах "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийн 2 дахь шатны үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн дарга:	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Гэрэлмаа	-Эрүүл мэндийн газрын дарга
Гишүүд:	С.Хэнчмэдэхгүй	-Эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга
	С.Мөнхцэцэг	-Боловсрол соёл, урлагийн газрын дарга
	Л.Мэндбаяр	-Нэгдсэн эмнэлгийн дарга
	Ж.Хонгорзул	-"Хэрлэн дом" Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч
	О.Сайханбилэг	-"Оюуны шим" Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгчийг түр орлон гүйцэтгэгч
	Ч.Уранцэцэг	-"Ач манал" Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч
	Г.Нямхатан	-Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал

2//.

2. "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийн 2 дахь шатны нээлтийн арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан ажлын хэсгээр хэлэлцүүлэн батлуулж удирдамжийн дагуу хариуцлагатайгаар зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч Л.Лхагвахатан/-д даалгасугай.

3. Сумын зорилтод насны иргэдийг элэгний эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд бүрэн хамруулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА